



МБНН

МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Монгол Улс хүн төрөлхтний хөгжлийн жам ёсны дагуу ардчиллын замд гараагаа эхэлж байсан 1992 оны 4 дүгээр сарын 7-нд Монголын Бүгд Найрамдах Нам /анх Монголын Хөрөнгөтний Нам нэрээр бүртгүүлсэн/ үүсэн байгуулагдсан юм.

МБНН "Иргэн баян бол улс баян" гэсэн үзэл баримтлалын дор ард түмнээ нийтээр нь хөрөнгөжүүлэх, үндэсний үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэх замаар монгол хүний оюун ухаан, хөдөлмөр шингэсэн материаллаг баялгийг өөрсдөө үйлдвэрлэх, хөдөлмөрийн үнэлгээг бодит түвшинд хүргэх зорилгоор 1992, 1996 оны Улсын Их Хурлын сонгуульд оролцож, бодит бөгөөд өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой Мөрийн хөтөлбөрөө дэвшүүлж байсан боловч үүнийгээ хэрэгжүүлэх боломж олдож байсангүй.

Улс орны хөгжлийн сүүлийн 10 жилд МАХН, МҮАН, МСДН-дын ээлжлэн барилцсан гурван төрийн үед нийгэм, эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтүүдийн хувьд олон арван жилээр ухралт хийж, улс орны тусгаар тогтнол, ардчилалд бодит аюул нүүрлээд байна.

Энэ эгзэгтэй мөчид МБНН өөрийн Мөрийн хөтөлбөрөө шинэчлэн боловсруулж ард түмэндээ толилуулж байна.

МБНН-ын Эрхэм Зорилго

МБНН нь неолибералист үзэл баримтлалыг онол суртахууныхаа үндэс болгосон прагматик /цогцлон байгуулагч/ шинжтэй баруун төвийн нам мөн.

МБНН-ын эрхэм зорилго нь:

- ◆ Үндэсний уламжлалт үзэл, төсөөллийн өвөрмөц үнэт зүйлсийг дэлхий нийтийн улс төрийн сонгодог үзлийн үнэт зүйлстэй зөв хослуулах;
- ◆ Монгол Улсын тусгаар тогтнол, төрт ёсны уламжлалыг дээдлэн сахих;
- ◆ Өвөг дээдсээс өвлөн авсан эх нутаг, газар шороогоо нүдний цөцгий мэт хайрлан хамгаалах эх оронч, экологич хүмүүжлийг төлөвшүүлнэ;
- ◆ Хүний эрх, эрх чөлөөт байдлыг хүндэтгэн дээдлэх зарчмыг хуулийн өмнө хүн бүр адил тэнцүү хариуцлага хүлээх зарчимтай жигд хослуулах;
- ◆ Оюуны багтаамжтай дэвшилтэт төхник төхнологи бүхий экспортод чиглэсэн үндэсний үйлдвэр дээр үндэслэсэн аж үйлдвэржсэн орон болох эх суурийг тавих;
- ◆ Монгол эх орон, газар шороогоо гэсэн элгэн халуун сэтгэлтэй, шударга ёс, ажил хөдөлмөр, эрдэм оюуныг эрхэмлэн дээдлэгч, эрүүл саруул бие бялдартай, чинээлэг хангалуун амьдралаа өөрийн шударга хөдөлмөрөөр буй болгохыг эрмэлзэгч монгол хүнийг төлөвшүүлэн хөгжүүлэх;
- ◆ Эдийн засагт хувийн секторын хөгжлийн давуу байдлыг хангахдаа хөдөлмөр хуваарилалтын шинэ зарчмыг үндэс болгон ард иргэдэд бизнес эрхлэх таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэхийн зэрэгцээ монгол хүний аж төрөх нөхцөлийг бүрдүүлэх замаар хот хөдөөгийн ахуйн нөхцөлийн ялгааг арилгах;
- ◆ Шинжлэх ухаан, соёл, боловсролын салбарын хөгжлийг төрийн бодлогын

- ◆ Иргэн бүр даатгуулагч байх, даатгалын үр шимийг шууд хүртдэг байхад даатгалын тогтолцоог боловсронгуй болгон өөрчлөх;
- ◆ Гадаад орнуудтай эрх тэгш, харилцан ашигтай хамтран ажиллахад оршино

Нэг. Эдийн засгийн бодлого

Монгол орныхоо тусгаар тогтнол, эрх чөлөөт байдлаа эдийн засгийн талаар баталгаажуулах нь намын эдийн засгийн бодлогын үндсэн зорилт байх ёстой гэж үзнэ. Үүний тулд:

- ◆ Эдийн засагт төрийн ухаалаг зохицуулалт байх ёстойг хүлээн зөвшөөрөхдөө төр, засаг үйлдвэрлэлийг дэмжигч, дотоодын зах зээлээ хамгаалагч аргаар хүчин байх ёстой гэж үзнэ;
- ◆ Улс орноо аж үйлдвэржүүлэх, оюуны багтаамж ихтэй, хамгийн орчин үеийн дэвшилтэт техник, технологи бүхий өөрсдийн байгалийн баялаг, мал аж ахуйн гаралтай түүхий эдэд түшиглэсэн олон улсын стандартад нийцсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндэсний үйлдвэрүүдийг бий болгох цогцолбор арга хэмжээг хэрэгжүүлэх;
- ◆ Эдийн засагт хувийн секторын эзлэх хувийн жинг нэмэгдүүлэхдээ бизнес эрхлэх таатай орчин нөхцөлийг бий болгон, шударга өрсөлдөөнд дэмжихийн хамт хөдөлмөр хуваарилалтын цоо шинэ зарчмыг нэвтрүүлэх;
- ◆ Гадаадын зээл тусламжийн ашиглалтад хатуу хяналт тавьж, түүнийг бүс нутгийн жигд хөгжлийг хангах, зөвхөн үндэсний үйлдвэрлэлийг өргөтгөх хөгжүүлэхэд зарцуулах;
- ◆ Албан татварын тогтолцоог боловсронгуй болгож, хамрах хүрээг өргөтгөх хувь хэмжээг зөв, оновчтой тогтоох;
- ◆ Улс орны цаашдын хөгжлийг хангахад дэд бүтцийн хөгжил онцгой ач холбогдолтой гэж үзэж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэхдээ төрөөс онцгой анхаарах;
- ◆ Түлш, эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлэх, нефтийн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр барьж байгуулах ажлыг төрөөс дэмжиж, шатаахуйн дотоодын хэрэгцээг өөрсдөө хангахыг чухалчлах;
- ◆ Микро түвшний эдийн засгийн хөгжлийг хангах зорилттой нягт уялдаатайгаар орон нутгийн бие даасан байдлыг хангах чиглэлээр төсвийн бүрдүүлэлт хуваарилалтыг зохицуулах;
- ◆ Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр татвар, зээл, хөрөнгийн оруулалтын уян хатан бодлого явуулах;
- ◆ Хөдөө аж ахуйн эрчимт хөгжлийг хангаж, экологийн цэвэр бүтээгдэхүүний дотоодынхоо хэрэгцээг хангах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн салбарыг дэмжих, хөдөө аж ахуйг бүсчлэн хөгжүүлэх цогцолбор арга хэмжээг хэрэгжүүлэх;
- ◆ Бүс нутгийн хөгжлийг хангах үүднээс эдийн засгийн нээлттэй бусүүдийг бий болгож хөгжүүлэх;
- ◆ Газар бол ард түмний өмч хэмээн үзэж газрыг монгол хүн үнэ төлбөргүй эзэмших, малын бэлчээр нутгийг хамгаалах чиглэл баримтлах.

Хоёр. Улс төрийн хүрээнд намаас баримтлах бодлого

- ◆ Эх орныхоо эрх ашиг, эрх чөлөөт байдал, ардчилсан төрт үндэсний уламжлал, мөн чанарыг эрхэмлэн дээдлэгч, алсын хараатай, хүртэцгүй бодлого баримталсан, олон ургальч үзэлд суурилсан, ард түмнийхээ итгэлийг даах, хүчтэй, шударга төр Монгол Улсын улс төрийн тогтолцооны цөм болж ёстой гэж үзнэ.

- ◆ Төрийн бодлогыг хэрэгжүүлэх гол хүчин зүйл нь төр, засгийн бүх шатны байгууллага, тэдгээрт ажиллагсад гэж үзэж, улс төрийн албан тушаалтны хариуцлага, сахилга, ёс зүйн хэм хэмжээнд тавигдах шаардлагыг өндөржүүлэн, хариуцлага тооцох механизмыг боловсронгуй болгохын зэрэгцээ төрийн албан хаагчдыг үзэл бодол, намын харьяалал, нас, хүйс, шашин шүтлэгээр нь ялгаварлахгүйгээр зөвхөн мэдлэг, чадвар, ажлын хариуцлага, ёс зүйн хэм хэмжээг нь гол шалгуур болгоно.
- ◆ Ардчилсан, хүчтэй төрийг төлөвшүүлэх нэг үндсэн нөхцөл нь чөлөөт хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэдгийг хүлээн зөвшөөрөхийн хамт хэвлэл мэдээлэл, үнэн бодит мэдээ, материалаар баримтжин баталгааждаг, үүнийхээ төлөө хариуцлага хүлээдэг, хүн ардынхаа оюуны хэрэгцээг хангадаг байх зарчмыг иш үндэс болгон чөлөөт хэвлэл мэдээллийн хөгжлийг бүх талаар хөхиүлэн дэмжихийн хамт дайн, хүчирхийлэл, садар самууныг сурталчлан дэлгэрүүлэхийг хориглох эрх зүйн үндсийг бүрдүүлнэ.
- ◆ Төрт ёсныхоо уламжлалыг сэргээх, дэлхийн улс гүрнүүдийн төрийн тогтолцооны дэвшилтэт зүйлсийг хослуулан төрийн тогтолцоо, ялангуяа төрийн дээд эрх мэдлийн хуваарилалтыг боловсронгуй болгоно.
- ◆ Төрөөс хуулийг хэрэгжүүлэх, нийгмийн дэг журам, шударга ёсыг ханган биелүүлэхэд хүчний байгууллагуудын үйл ажиллагаа, тэдгээрт ажиллагсдын сахилга, ёс зүй онцгой ач холбогдолтойг үндэс болгон хүчний байгууллагуудыг бүх талаар бэхжүүлэх, ажиллагсдынх нь ахуй хангамжийг сайжруулах арга хэмжээг тусгайлан авч хэрэгжүүлэхийн зэрэгцээ, албан үүргээ гүйцэтгэж яваад амь эрсэдсэн тохиолдолд ар гэрийнх нь амьдралын баталгааг бүрэн хангах асуудлыг хуульчлан тогтооно.

**Гурав. Нийгэм, соёл, оюун санааг хүрээнд намаас
баримтлах бодлого**

- ◆ Төрийн бодлогын төв нь монгол хүн, улс орны хөгжил дэвшлийн үндсэн нөхцөл нь хүний хөгжил байна гэсэн зарчимд тулгуурласан нийгмийн бодлогын цогц арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- ◆ Нийгмийн халамж, нийгмийн даатгалын тогтолцоог даатгуулагч үр шимийг нь шууд хүртдэг байхаар боловсронгуй болгон өөрчилнэ.
- ◆ Монгол Улсын иргэд суурь боловсролыг үнэ төлбөргүй эзэмших нөхцөлийг хангана.
- ◆ Хүн ардынхаа чинээлэг хангалуун амьдралыг тэдний шударга, уйгагүй, бүтээлч хөдөлмөрийн үрээр цогцлуулахыг эрмэлзэн, түүнд төрөөс тодорхой дэмжлэг үзүүлж, ажилгүйдэл, ядуурлыг гэтлэн давах арга хэмжээг тодорхой үе шаттай авч хэрэгжүүлнэ.
- ◆ Хөдөө орон нутаг, төв сууринд ажиллаж амьдарч байгаа иргэдийн соёл, ахуй амьдралын нөхцөлийг сайжруулах бодлогыг тууштай авч хэрэгжүүлсний үндсэн дээр хөдөө дахь амьжиргааны өртгийг эрс багасгана.
- ◆ Монгол төрийн оршин тогтнох үндэс нь Монгол Хүн гэсэн зарчмыг баримтлан ард түмнийхээ эрүүл мэндийг хамгаалах зорилтыг хэрэгжүүлэх бөгөөд энэ үүднээс эрүүл мэндийн салбарт техникийн шинэчлэл хийх, эмнэлгийн байгууллагын ажилтнуудын ажиллаж амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах, цалин хангамжийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарна.
- ◆ Монгол өрх бүр өөрийн гэсэн гал голомттой байх ёстой гэж үзэж, ялангуяа хот, суурин газрын иргэдийг өөрсдийн хүчээр орон байртай болгох, эдийн засаг, эрх зүйн орчинг бүрдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг чармайна.
- ◆ Монгол хүн, хөдөлмөрийн нөөцийн хөгжлийн үзүүлэлтэд онцгой анхаарч, шинжлэх ухаан, боловсролын салбарын хөгжлийг тэргүүлэх чиглэл гэж үзэж онцгой анхаарна.

- ◆ Хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлогыг хэрэгжүүлэхэд анхаарна.
- ◆ Эх оронч үзэл, үндэсний бахархал, өндөр боловсрол, бие даан өөрчлөгч хөгжүүлэх чадвар, дадал, хөдөлмөрч шударга зан чанарыг төлөвшүүлэх сургалт, хүмүүжлийн ажлыг чиглүүлэн бүх шатны сургуулийн сургалтыг агуулга, арга зүйг боловсронгуй болгон өөрчилнө.
- ◆ Шинжлэх ухааны тогтолцоог өөрчлөн шинэчилж, Монгол эрдэмтдийн бүтээгдэхүүнийг нөхцөл, бололцоог бий болгон шинжлэх ухааны чадамж, бүтээмж дэмжин хөгжүүлэх, оюуны үнэлэмжийг бодитой болгохыг эрмэлзэнэ.
- ◆ Соёл, урлаг, биеийн тамирын салбарын хөгжлийг төрийн ивээлд байгуулж түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах, сэргээн засварлах, музейн хөмрөгийг арвижуулах, засварлах чиглэлээр хөрөнгө оруулалт хийж дэмжих чиглэл баримтална.
- ◆ Оюуны бүтээл, зохиогчийн халдашгүй өмч нийгмийн баялаг байх ёстой түүний үнэлэмжийг нэмэгдүүлэх, онцгой авьяасыг хөхиүлэн дэмжих эрмэлзэнэ.

Дөрөв. Гадаад бодлого, аюулгүй байдлын талаар баримтлах бодлого

- ◆ Олон улсын харилцааны нийтлэг зарчим, үнэт зүйлсийг хүндэтгэн, үннэг орныхоо язгуур эрх ашигт нийцүүлэн гадаад орнуудтай эрх, тэгш харилцаа ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлнэ.
- ◆ Монгол төрийн гадаад бодлогод хөрш хоёр оронтойгоо найрсаг харилцааныг хөгжүүлж хамтран ажиллах асуудал онцгой байр эзлэхийн зэрэгцээ хязгаарын бүрэн бүтэн байдлыг хамгаалах, хил орчмын ард иргэдийн амгалан аж төрөх нөхцөлийг хангана.
- ◆ Үндэсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн цэгцтэй бодлого үзүүлж үндэсний аюулгүй байдлын тогтолцоог боловсронгуй болгоно.
- ◆ Төрт ёсны уламжлал, олон улсын дэвшилтэт үзэл баримтлалд тулгуурлан монгол цэргийн номлолыг боловсронгуй болгох чиглэл баримтална.

Монгол Улсын иргэн гадаадад чөлөөтэй зорчих, тухайн орны иргэдтэй адил нөхцөлд амьдарч хөдөлмөрлөх, хөдөлмөрөө үнэлүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудлыг төр засгийн хэмжээнд хэлэлцэн тохирч баталгаажуулах зорино.

Улаанбаатар хот
2000 он